

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЗЭСЭНСҮРЭНГИЙН НАЦАГНЯМЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, цахим технологид суурилсан эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулна”							
1.	Арга хэмжээ:1.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг нэмэгдүүлэх бодлого, зохицуулалтыг оновчтой арга хэлбэрээр зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан нийт иргэдийн хувь	80%	90%	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, эрх зүйн сургалт, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий төрийн алба хаагчид буюу эрх зүйн хөтчийн тоог нэмэгдүүлж, жил бүр тодорхой салбар эрх зүйн чиглэлээрх эрх зүйн хөтчийн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж хэвшээд байна. Мөн аймгийн Хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын нэгдсэн төлөвлөгөөнд салбарын хууль тогтоомж сурталчлах өдөрлөгийг холбогдох байгууллагууд хамтран зохион байгуулах хуваарийг тусган батлуулж, өдөрлөгийг тогтмол зохион байгуулж байна. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд иргэдэд анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий 70 эрх зүйн хөтчийг бэлтгэн хамтран ажиллаж байна.	2024.01.02 2024.12.04	90.0

					Тус оны эрх зүйн сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг 2024 оны А/170 дугаар захирамжаар төлөвлөгөөг батлан, сум, агентлагуудад хүргүүлж, нэгдсэн удирдлагаар ханган, хэрэгжүүлж ажиллав. Шинээр хэрэгжиж эхэлсэн хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах, иргэдэд мэдээлэл түгээх, нээлттэй өдөрлөг зохион байгуулах, хяналт шалгалт хийх зэрэг нийт 4 хэсгээс бүрдсэн 37 арга хэмжээг төлөвлөн, төлөвлөгөөг 90 хувьтай хэрэгжүүлсэн байна.		
2.	Дэд арга хэмжээ 1.1.1: Төрийн байгууллагуудын сургалт, мэдээлэл хариуцсан алба хаагчдад сургалт зохион байгуулах, үйл ажиллагаанд зөвлөн туслана.	Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо	80%	100%	Сумдын Хууль, эрх зүйн хариуцсан мэргэжилтэн, Насан туршийн суралцахуйн багш, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт хоршооны эрх зүйн чиглэлээрх эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх арга зүйн сургалтыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагатай хамтран 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, сургалтад нийт 50 алба хаагчийг оролцуулж, гэрчилгээ олгож ажилласан.	2024.05.20 2024.12.04	100.0
3.	Дэд арга хэмжээ 1.1.2: 2024 оны Эрх зүйн сургалт, сурталчилгааны аймгийн нэгдсэн төлөвлөгөөг гарган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	100%	Аймгийн хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2024 оны нэгдсэн төлөвлөгөөний төсөлд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас санал авч, нэгтгэн боловсруулан аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/170 дугаар захирамжаар батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах хүрээнд захирамжийн хувийг нэгжийн даргын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 3-2/128 дугаар албан бичгээр сум, байгууллагуудад хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.	2024.01.06 2024.12.04	90.0

4.	Дэд арга хэмжээ 1.1.3: Шинээр батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төсөл, бусад холбогдох хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад тухай бүр дэмжлэг үзүүлнэ.	Хамтран зохион байгуулсан сургалтын тоо	100%	100%	Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/170 дугаар захирамжаар батлагдсан аймгийн хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2024 оны нэгдсэн төлөвлөгөөний 1 чиглэл нь шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах зорилтыг тусган батлуулсан. Шинээр батлагдсан хууль тогтоомжийн сургалт сурталчилгааг сурталчлах ажлыг сумдын Хууль, эрх зүйн мэргэжилтнүүд болон Засаг дарга нар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний холбогдох агентлагийн дарга нарт чиглэл өгч, сургалт, сурталчилгааг зохион байгуулж ажиллав. Тайлант хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуулийн төсөл, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төсөл, Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Сууц өмчлөгчдийн холбооны тухай хуулийн төсөл зэрэг бусад https://d.parliament.mn/ сайтад байршуулсан хууль тогтоомжийн төслүүдэд санал авах ажиллагааг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хууль тогтоомж сурталчлах төв, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар зэрэг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Мөн жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдөр Хуульчийн пробоно өдөрлөгийг Хуульчдын холбооны салбартай хамтран зохион байгуулж хэвшээд байгаа бөгөөд өдөрлөгөөр шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар иргэдэд гарын авлага, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.	2024.01.06 2024.12.04	100.0
5.	Арга хэмжээ:1.2. Цахим технологид суурилсан	-	90%	90%	Аймгийн албан ёсны веб сайт uvurkhangai.gov.mn болон E-khutuch цахим хуудасны “Хууль, эрх зүйн	2024.01.06 2024.12.04	90.0

	арга хэлбэрээр хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааг зохион байгуулна.				зөвлөгөө мэдээлэл” цэсэд хууль, эрх зүйн талаарх мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааг байршуулан олон нийтэд хүргэж байна. Мөн иргэдэд цахимаар хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг түлхүү өгөх чиглэлээр Эрх зүйн хөтчийн буланг нийт сумдад байгуулахаар сумдад чиглэл өгч ажиллаж тайлант хугацаанд нийт 14 суманд эрх зүйн хөтчийн буланг байгуулан иргэд цахимаар зөвлөгөө мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж байна.		
6.	Дэд арга хэмжээ 1.2.1: Эрх зүйн хөтчийн булан байгуулаагүй сумдад эрх зүйн хөтчийн булан байгуулж, идэвхижүүлж ажиллах чиглэлийг шат дараалалтай өгч, арга зүйн зөвлөмжөөр хангана.	Шинээр байгуулагдсан эрх зүйн хөтчийн булангийн тоо	100%	100%	Эрх зүйн хөтчийн булан байгуулаагүй сумдад 2024 оны 03 дугаар улиралд багтаан эрх зүйн хөтчийн булан байгуулах чиглэл, зөвлөмжийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга болон Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүдэд “ӨВ-ХЭЗМ” цахим бүлгээр өгч ажилласан. Мөн эрх зүйн хөтчийн булан байгуулсан сумдад e-khutuch.mn системийн мэдээлэл, зөвлөгөөг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн санг баяжуулах талаар чиглэл өгч ажиллав. Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнд Эрх зүйн хөтчийн 2024 оны ажлын тайланг нэгтгэн гаргаж Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн арга зүйчийн tsetsegdari@legalinstitute.mn хаягаар илгээсэн. 2024 онд 4 суманд эрх зүйн хөтчийн буланг шинээр байгуулсан байна.	2024.01.06 2024.12.04	90.0
7.	Дэд арга хэмжээ 1.2.2: Uvurkhangai.mn сайтын Хууль, Эрх зүйн зөвлөгөө мэдээлэл цэсэнд шинээр батлагдсан хууль тогтоомж, дүрэм журмын талаарх мэдээлэл, сурталчилгааг байршуулж иргэдэд цахим технологийг	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цэсэнд байршуулсан мэдээллийн тоо	90%	100%	Uvurkhangai.mn сайтын Хууль, Эрх зүйн зөвлөгөө мэдээлэл цэсэд шинээр батлагдсан хууль тогтоомжийг байршуулан нийтэд сурталчлан ажиллаж байна. Мөн Тайлант хугацаанд 2024 онд шинээр батлагдсан болон шинэчлэн батлагдсан нийт 20 хууль тогтоомжийг цахимд байршуулан иргэд, олон нийтэд сурталчлан ажиллалаа. Мөн d.parliament.mn сайтад байршуулсан хууль тогтоомжийн төсөлд төрийн холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг зохион	2024.01.06 2024.12.04	90.0

	ашиглан эрх зүйн мэдээллийг хүртээмжтэй хүргэнэ.				байгуулж, хууль тогтоомжийн төсөлд иргэдийн саналыг авч ажиллаж байна.		
Зорилт 2. “Аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол Улсын Шадар сайдтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж, үр нөлөөний шинжилгээ хийж ажиллана”							
8.	Арга хэмжээ 2.1. Аймгийн Засаг даргаас Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.	Хэрэгжилтийн хувь	96.8%	98%	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол Улсын Шадар сайдаас аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээнд тусгуулах саналыг нэгтгэж, эцэслэн боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд болон Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд тус тус 1 дүгээр сард цахим хаягаар хүргүүлж ажилласан. Монгол улсын Шадар сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаас гэрээний хэрэгжилттэй холбоотой зохион байгуулсан цахим уулзалтад 01 дүгээр сарын 11, 19-ний өдрүүдэд харьяа хууль, хяналтын байгууллагын удирдлагын хамт оролцож, гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд анхаарах асуудлын талаар зөвлөгөө, чиглэл өгч ажилласан. Аймгийн Засаг даргаас Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээг хэрэгжүүлж ажиллах тухай нэгжийн даргын албан бичгийг гэрээний хувийн хамт харьяа хууль хяналтын байгууллагуудад 01 дүгээр сард хүргүүлсэн. Гэрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн Засаг даргаас шийдвэрлэх асуудлыг аймгийн Засаг даргад танилцуулж зарим арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулан ажиллав. Мөн гэрээнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд хууль, хяналтын байгууллагуудаас хөрөнгө шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргад	2024.01.03 2024.12.04	100.0

					ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлүүлэхээр аймгийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан нийт 142 сая төгрөгийг хууль, хяналтын байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлсэн шийдвэрийг аймгийн Засаг даргын 2024 оны А/105, А/620, А/670 дугаар захирамжуудаар шийдвэрлүүлсэн байна.		
9.	Дэд арга хэмжээ 2.1.1: Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	91.3%	95%	Аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг хуулийн байгууллагуудад өгч, гэрээнд тусгагдсан 6 зорилт тус бүрийн хүрээнд холбогдох байгууллага бүрд төлөвлөгөөг гаргуулан, биелэлтэд хяналт тавин, холбогдох арга хэмжээг хамтран зохион байгуулан, аймгийн Засаг даргаас үүрэг хүлээсэн шийдвэрлэх арга хэмжээг шийдвэрлүүлэн ажиллав.	2024.02.15 2024.12.04	100.0
10.	Дэд арга хэмжээ 2.1.2: Шадар сайдаас аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг боловсруулан батлуулна.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	90%	Аймгийн Засаг даргаас Монгол улсын Шадар сайдтай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг орон нутаг дахь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад өгч, гэрээнд тусгагдсан 4 чиглэлийн хүрээнд арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох байгууллага бүрд гаргуулан, биелэлтэд хяналт тавин, холбогдох арга хэмжээг хамтран зохион байгуулж, мөн аймгийн Засаг даргаас үүрэг хүлээсэн шийдвэрлэх арга хэмжээг шийдвэрлүүлэн ажиллав.	2024.02.15 2024.12.04	100.0
11.	Дэд арга хэмжээ 2.1.3: Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, үр	Гэрээний хэрэгжилтийн хувь	2023 оны гэрээний хэрэгжилт 91.8 хувьтай үнэлэгдсэн.	95%	Хууль зүй дотоод хэргийн сайдаас аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээг 6 зорилт 33 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр батлуулан, хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж, ХЗДХЯаманд хүргүүлсэн. Мөн гэрээний хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг хуулийн байгууллагуудаас авч, нэгтгэн үр нөлөөний шинжилгээ хийгээд байгаа	2024.01.20 2024.12.04	100.0

	нөлөөний шинжилгээ хийнэ.				бөгөөд мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээр хяналт, шинжилгээ хийлгэн, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 12 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэхээр ажиллаж байна. Тайлант хугацаанд гэрээний хэрэгчилт 93 хувийн хэрэгжилттэй байна. Үр нөлөөний шинжилгээ хийхэд төсөв хөрөнгө зарцуулахгүй зохион байгуулагдах арга хэмжээний хэрэгжилт хангалттай 100 хувийн үнэлгээтэй байгаа бөгөөд биелэлт хангалтгүй байгаа арга хэмжээнүүд нь санхүүжилтийн эх үүсвэр хүрэлцээгүйн улмаас хангалтгүй байна. Төсөвт өртөг шаардлагатай арга хэмжээг боломжит бүх хэлбэрээр хэрэгжүүлж ажиллах боломж нөхцөлийг судлаж, холбогдох байгууллагуудад чиглэл өгч ажиллалаа.		
12.	Дэд арга хэмжээ 2.1.4: Шадар сайдаас аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, үр нөлөөний шинжилгээ хийнэ.	Гэрэ-эний хэрэгжилтийн хувь	2023 оны гэрээний хэрэгжилт 91.7 хувьтай үнэлэгдсэн.	90%	Шадар сайдаас аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллах гэрээг харьяа байгууллагуудад хэрэгжүүлэн ажиллах чиглэлийг 01 дүгээр сард хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Гэрээний хэрэгжилтийн тайланг 12 дугаар сарын 15-ны дотор Шадар сайдын ажлын албанд тайлагнахаар холбогдох байгууллагуудаас тайланг авч, нэгтгэн, хяналт үр нөлөөний шинжилгээ хийж ажиллаж байна. Тайлант хугацаанд гэрээний хэрэгчилт 94 хувийн хэрэгжилттэй байна.	2024.05.06 2024.12.04	100.0
Зорилт 3. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулж, нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийг арга зүйгээр хангаж ажиллана.							
13.	Арга хэмжээ 3.1. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	90%	Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн Засаг даргын хуульд заасан эрх, үүргийн хүрээнд аймгийн Цагдаагийн газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж, мөн дэмжлэг үзүүлэн ажиллав. Тухайлбал: Замын хөдөлгөөний	2024.02.20 2024.12.04	100.0

				аюулгүй байдлыг хангуулах хүрээнд Зөрчлийн улмаас түр саатуулагдсан тээврийн хэрэгслийн талаар авах зарим арга хэмжээний тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 16/04 тогтоолын хэрэгжилтийг хуралд танилцуулах материалыг бэлтгэн 02 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар мөн тус сард иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн хурлаар аймгийн Цагдаагийн газартай хамтран танилцуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн “Төлбөрийн хэмжээ шинэчлэн тогтоох тухай” 25/03 дугаар тогтоолоор Зөрчлийн улмаас түр саатуулагдсан тээврийн хэрэгслээс хоногт хураах төлбөрийн хэмжээг шинэчлэн батлуулж, мөн Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүргүүлэн, тогтоолыг хэрэгжүүлж ажиллах чиглэлийг аймгийн Цагдаагийн газарт нэгжийн даргын 2024 оны 05 дугаар сарын албан бичгээр хүргүүлсэн. Мөн хүүхэд өсвөр үеийнхнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд Цахим тоглоомын газрын үйлчилгээтэй холбогдуулан сумдын Засаг дарга нарт аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 1/143 албан бичгээр чиглэл, зөвлөмжийг хүргүүлэв. Тээврийн Цагдаагийн албанаас аймгийн Засаг даргад хамтран ажиллах талаар ирүүлсэн хүсэлтийн хүрээнд тус аймгийн Замын Цагдаагийн тасгийн алба хаагчдыг эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/202 Дэмжлэг үзүүлэх тухай захирамж батлуулан, хувийг аймгийн Цагдаагийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүд хүлээлгэн өгч ажиллав.		
--	--	--	--	---	--	--

14.	Дэд арга хэмжээ 3.1.1: Амар тайван Өвөрхангай хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, эрчимжүүлж ажиллана.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2023 оны биелэлт 90%	100%	Аймгийн Цагдаагийн газарт Амартайван Өвөрхангай хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах чиглэлийг тухай бүрд өгч тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хамтран зохион байгуулан ажиллав. Амартайван Өвөрхангай хөтөлбөрийн 2021-2024 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсээр хяналт, үнэлгээ хийлгүүлж 05 дугаар сард аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэв. Тайлант хугацаанд хөтөлбөрийн биелэлт 90.06 хувийн хэрэгжилттэй байна.	2024.04.15 2024.12.04	100.0
15.	Дэд арга хэмжээ 3.1.2: Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, хяналтын камерын системийг хөгжүүлнэ.	Шинээр нэмэгдсэн хяналтын камерын тоо	2023 онд Камержуулалт 4 аян зохион байгуулагдсан	90%	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Цагдаагийн газартай хамтран Арвайхээр сумын хөгжлийн төсвийн хөрөнгөөр хяналтын камерын өргөтгөлийг Арвайхээр сумын 2, 4, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар багуудын нутаг дэвсгэрт нийт 21 хяналтын камер байршуулуулахаар шийдвэрлүүлэн хяналтын камерыг байршуулуулан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажилд ашиглаж байна. Мөн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж Камержуулалт-5 буюу “Ногоон бүс” төслийн хүрээнд Арвайхээр сум 5-р багт 100 сая төгрөгийн санхүүжилтээр 6 цэгт PTZ-4, чиглэл 17 телехяналтын камер, Хархорин сум 1, 2, 3 багт 142 сая төгрөгийн санхүүжилтээр 23 цэгт 60 телехяналтын камерыг тус тус суурилуулсан байна.	2024.02.30 2024.12.01	100.0
16.	Дэд арга хэмжээ 3.1.3: Харьяа хууль, хяналтын байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын	Зөвлөгөөнд оролцсон алба хаагчдын тоо	2021 онд зөвлөгөөн зохион байгуулж, санамж	80%	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран хуулийн байгууллагуудын зөвлөгөөн, нээлттэй өдөрлөг, сургалт арга хэмжээг Хүний эрх, Авлигын эсрэг ёс гэгээрүүлэх арга хэмжээ, хүүхэд хамгаалал	2024.05.10 2024.06.07	90.0

	зөвлөгөөнийг зохион байгуулж, санамж бичиг байгуулж, хэрэгжилтэд хянал тавих.		бичиг байгуулсан		сэдвээр нийт 7 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан. Тухайлбал, 2024 оны 5 дугаар сард Хуульчийн про боно 2024 – Төрийн байгууллагуудын нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж, арга хэмжээг сонирхолтой, онцлог байдлаар зохион байгуулан ажилласан. Тухайлбал иргэдэд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөхийн зэрэгцээ, иргэдийн оролцоог хангах хүрээнд The Open Mic интертеймент үйл ажиллагаа, АХА тэмцээн уралдаан зохион байгуулж, Мөн Бүсийн Шүүхийн шинжилгээний төв болон Цагдаагийн газраас үзүүлэнгийн техник хэрэгслүүд үзэгч, сонирхогч ихтэй байж үйл ажиллагааг өргөн болгосон. Өдөрлөгт хууль, хяналтын байгууллагууд болон бусад нийт 12 байгууллагаас давхардсан тоогоор нийт 187 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 1500 гаруй иргэнд салбарын хууль тогтоомжийн чиглэлээр мэдээлэл өгч ажилласан.		
17.	Арга хэмжээ 3.2. Нотариатын үйл ажиллагаанд хяналт тавьж, эрх олгуулах ажлыг зохион байгуулж, арга зүйгээр хангаж ажиллана.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	90%	Сумдын нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд зөвлөн туслах чиглэлээр “ӨВ.Нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нар” цахим бүлгийг ажиллуулж арга зүйн зөвлөмжөөр ханган, нотариатын үүрэг гүйцэтгэгчдээс асуусан асуултад тухай бүрд хариулт чиглэл, өгч, ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн яам, Нотариатчидын танхимтай хамтран сумдын нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэгч нарт 03 дугаар сарын 26-ны өдөр арга зүй өгөх чиглэлээр цахим сургалтыг зохион байгуулж, үүрэг гүйцэтгэгч нарт сургалтын материалыг цахимаар хүргүүлж ажилласан.	2024.01.03 2024.12.04	90.0
18.	Дэд арга хэмжээ 3.2.1: Нотариатчийн үүрэг гүйцэтгэх эрх авах хүсэлтийг тухай бүрт	Шийдвэрлэсэн хүсэлтийн тоо	Хүсэлт ирүүлсэн асуудлыг тухай бүрт	30%	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 16 суманд нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэгч ажиллаж байна. Сант сумын Хууль, эрх зүйн мэргэжилтэнд	2024.01.03 2024.12.04	100.0

	холбогдох газарт уламжилж, эрх олгуулна.		шийдвэрлэж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан байна.		Нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэгчийн эрхийг олгуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн албан бичгээр хүсэлтийг хүргүүлэв.		
19.	Дэд арга хэмжээ 3.2.2: Нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	Арга зүйн зөвлөмжийн тоо	-	30%	Нотариатчийн үүрэг хавсран гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд зөвлөн туслан, хяналт тавин ажиллаж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Нотариатын танхимаас өгч буй зөвлөмж, чиглэлийг тухай бүрд хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд нотариатын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол гараагүй байна. Цаашид Нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааг цахимд нэвтрүүлэхээр төлөвлөн, туршлага судлан ажиллаж байна.	2024.01.03 2024.12.04	90.0
Зорилт 4. “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллана”							
20.	Арга хэмжээ 4.1. Орон нутагт Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад хяналт тавьж ажиллана.	Үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн тоо	2-оос доошгүй	90%	Орон нутагт Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр улсын байцаагчийг гэрээгээр ажиллуулж байгаа бөгөөд улсын байцаагчийн үйл ажиллагаанд зөвлөн туслан, хяналт тавьж хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын ажлын хэсэг болон улсын байцаагчтай хамтран орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын ажилтнуудад зориулсан арга зүйн сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулж, ажилласан. Мөн олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах захирамжийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргын 03 дугаар	2024.01.11 2024.12.04	100.0

					сарын 13-ны өдрийн Хөрөнгө зарцуулах тухай А/199 дүгээр захирамжийг батлуулан, орон нутаг дахь байцаагчид дэмжлэг үзүүлж ажиллав.		
21.	Дэд арга хэмжээ 4.1.1: Орон нутаг дахь ШӨХТГ-ын улсын байцаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллана.	Үүрэг чиглэл өгсөн тоо	3 удаа	90%	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон нутаг дахь улсын байцаагчийн үйл ажиллагаанд тухай бүрд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байна. Нэгжийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 3-2/45 дугаар албан бичгээр зөвлөмж өгч, холбогдох мэдээ, тайланг тогтоосон хугацаанд ирүүлж байх чиглэлийг өгсөн байна. Мөн сар бүр холбогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг хянаж холбогдох хэлтэст хугацаанд хүлээлгэн өгч мөн арга зүйгээр тухай бүрд ханган ажиллаж байна.	2024.01.23 2024.12.04	100.0
22.	Дэд арга хэмжээ 4.1.1: Улсын байцаагчийг 2024 онд ажиллуулах шийдвэрийг боловсруулан батлуулна.	Алба хаагчийн гэрээний хэрэгжилтийн хувь	Аймгийн Засаг даргын 2023 оны Б/01 дүгээр захирамж	80%	Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/02 дугаар захирамжаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын тус аймаг дахь улсын байцаагчийг гэрээгээр түр ажиллуулах тухай шийдвэрийг батлуулж, 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ажиллуулахаар шийдвэрлүүлсэн бөгөөд үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.	2024.01.17- 2024.06.07	100.0
23.	Дэд арга хэмжээ 4.1.2: Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай хамтран ажиллах гэрээг боловсруулан батлуулж, хяналт тавьж ажиллана.	Гэрээний хэрэгжилтийн хувь	2023 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан	10%	Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хангуулах зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Гомбосүрэнгийн Амардэлгэрийг тус аймаг дахь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажил хариуцсан ажилтнаар 2021 оноос хойш жил бүр гэрээ байгуулан ажиллуулж байна. Мөн орон нутагт улсын байцаагч ажиллуулахтай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газраас Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө	2024.01.17 2024.12.04	100.0

					газартай хамтран ажиллах гэрээг 2021 оноос байгуулж, улмаар жил бүр гэрээг сунган баталгаажуулан, улсын байцаагчийг орон нутгаас цалинжуулж, ажлын байр, шаардлагатай компьютер техник хэрэгсэл, бензин шатахуун зэрэг бусад зардлаар ханган ажиллаж байна.		
--	--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
Зорилт 1. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль болон орон нутгийн сонгууль зохион байгуулах аймгийн Сонгуулийн хорооны гишүүнээр ажиллах”							
1.	Сонгуулийн ерөнхий хорооны www.e-election.mn цахим системд аймаг, сумдын сонгуулийн хорооны алба хаагчдыг бүртгүүлэх, шалгалт өгөх, сертификат олгуулах заавар, зөвлөмжөөр хангах	Гэрчилгээ авсан иргэдийн тоо	-	Аймаг, сумын сонгуулийн хороодод ажиллах алба хаагчид шалгалт өгч, гэрчилгээ авсан байна.	Сонгуулийн ерөнхий хорооны www.e-election.mn цахим системд аймаг, сумдын сонгуулийн хорооны гишүүдийг бүртгүүлж, шалгалт өгүүлэн, сертификат олгуулах заавар, зөвлөмжийг тогтмол өгч нийт 180 орчим алба хаагчдад сонгуулийн ерөнхий хорооны сертификатыг олгуулсан байна. Мөн цахим системтэй холбоотой заавар, зөвлөмжийг сумдын сонгуулийн хорооны дарга нарт тухай бүрд өгч ажиллаж байна.	2024.04.04 2024.06.07	100.0
2.	Сонгуулийн хууль тогтоомжийн сургалтыг хамтран зохион байгуулах	Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо	-	Холбогдох алба хаагчдыг сургалтад хамруулсан байна.	Сонгуулийн ерөнхий хороотой хамтран Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотойгоор 03 дугаар сарын 13-ны өдөр аймгийн сонгуулийн хороо болон Арвайхээр сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодод ажиллах алба хаагч нарт сонгуулийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд танхимын сургалтыг нийт 70	2024.03.12- 2024.04.01	100.0

					гаруй алба хаагч нарт зохион байгуулав. Мөн Сонгуулийн ерөнхий хороотой хамтран сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороодод ажиллах алба хаагч нарт Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан арга зүй өгөх цахим сургалтыг 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулав.		
3.	Сумдын Сонгуулийн хороо байгуулах шийдвэрийн төслийг боловсруулж, бүрэлдэхүүнийг www.e-election.mn цахим системд хянаж, баталгаажуулах	Шийдвэр алдаагүй байх	-	Шийдвэрийг батлуулан сумдад хүргүүлсэн байна.	2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн сумдын сонгуулийн хороо байгуулах тухай 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах сумын сонгуулийн хороог байгуулж, тогтоолыг сумдад хүргүүлж, www.e-election.mn цахим системд хянаж, баталгаажилт хийсэн.	2024.04.20 2024.04.28	100.0
4.	Сумдын сонгуулийн орооны дарга, нарийн бичгийн дарга нарын сургалт зохион байгуулах	Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоогоор	-	Сургалтад нийт сумдын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарыг хамруулсан байна.	Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулах үүрэг бүхий сумдын сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт сонгуулийн тухай хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах, сонгууль зохион байгуулалтын талаар арга зүйн зааварчилгаа өгөх сургалтыг 05 дугаар сарын 14-ний өдрийн 10-18 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 508 тоот танхимд 50 гаруй алба хаагчдыг оролцуулан зохион байгуулсан.	2024.05.08 2024.05.14	100.0
5.	Сонгогчийн өдөрлөг зохион байгуулах	-	-	Өдөрлөгийг 2 өдрийн турш зохион байгуулсан байна.	Сонгуулийн тухай хууль, тогтоомжийг сонгогчдод тайлбарлан таниулах, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үйл явцын талаарх мэдээ, мэдээллийг	2024.06.03 2024.06.07	100.0

					сонгогчдод хүргэх, саналын хуудасны загвар, санал тоолох төхөөрөмжийн ажиллагааг танилцуулах зорилгоор “Сонгогчийн өдөрлөг”-ийг 06 дугаар сарын 6,7-ны өдрүүд аймгийн Сонгуулийн хороо болон Арвайхээр сумын сонгуулийн хороотой хамтран аймгийн төв талбайд зохион байгуулж ажиллав.		
6.	Хүсэлт ирүүлсэн зарим сумдын сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж, батлуулах	-	-	Тогтоолын төслийг боловсруулж, батлуулсан байх	Аймгийн Сонгуулийн хорооны 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Зарим сумдын сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” 03 дугаар тогтоолоор Өлзийт, Гучин-Ус, Уянга сумдын сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан тогтоолыг аймгийн Сонгуулийн хорооны даргаар баталгаажуулан тус сумдад хүргүүлэв.	2024.05.13 2024.05.14	100.0
7.	Хөдөөгийн багуудын санал авах байрны аюулгүй байдлыг хангах тухай захирамжийн төсөл боловсруулж, батлуулах	-	-	Захирамжийг батлуулсан байх	Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан хөдөөгийн багуудад байршсан сүлжээгүй санал авах байрны судалгааг сумдаас авч нэгтгэн нийт 45 санал авах байрны аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардалд 19,820,000 төгрөгийг аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/481 дүгээр захирамжаар шийдвэрлүүлж, санхүүд захирамжийн эх хувийг хүлээлгэн өгсөн.	2024.06.07 2024.06.07	100.0
Зорилт 2. “Бусад чиглэлээр”							
8.	“Эх дэлхий- Элгэн нутаг” зорилтот байгаль хамгааллын өдөрлөгийг зохион байгуулах	Өдөрлөгт иргэдийг идэвхтэй оролцуулах	-	Өдөрлөгийг хамтран зохион байгуулсан байна.	Байгаль орчны хамгааллыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдээлэл олгох, орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй	2024.02.01 2024.02.07	100.0

					иргэдийн оролцоо манлайллыг дээшлүүлэх, байгаль орчны өнөөгийн нөхцөл байдалд хувь хүний оруулах эерэг хандлагыг уриалах зорилготой “Эх дэлхий- Элгэн нутаг” зорилтот байгаль хамгааллын өдөрлөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар болон АДЕI төрийн бус байгууллагатай хамтран 02 дугаар сарын 07-ны өдөр аймгийн Хүүхдийн ордны “Орхон кино театр”-т зохион байгуулж, өдөрлөгт 120 гаруй иргэдийг оролцуулж ажиллав.		
9.	Ерэн есөн сарнай” нөлөөллийг арга хэмжээг хамтран зохион байгуулах	-	-	Өдөрлөгийг хамтран зохион байгуулсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хангах хүрээнд 03 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж буй “Ерэн есөн сарнай” нөлөөллийг арга хэмжээг хамтран зохион байгуулахаар Арвайхээр сумын Засаг даргад аймгийн Засаг даргын 02 дугаар сарын 28-ны өдрийн 2/83 дугаар албан бичгийг хүргүүлэв. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийг хангах тэдний дуу хоолойг сонсох хүрээнд “Ерэн есөн сарнай” нөлөөллийн арга хэмжээг Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, АДЕL төрийн бус байгууллага болон бусад төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, арга хэмжээнд Арвайхээр сумын 99 эмэгтэйчүүдийг оролцуулж ажиллав.	2024.02.20 2024.03.08	100.0
10.	Багийн Засаг нарыг чадавхижуулах сургалтыг	-	-	Сургалтыг хамтран зохион	Удирдлагын академи, аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн	2024.03.01 2024.03.05	100.0

	хамтран зохион байгуулах			байгуулсан байна.	захиргааны удирдлагын хэлтэстэй хамтран тус аймгийн нийт багийн Засаг нарыг чадавхжуулах сургалтыг 03 дугаар сарын 04,05-ны өдрүүдэд аймгийн Политехникийн коллежийн сургалтын танхимд хамтран зохион байгуулж ажиллав.		
11.	Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ойг орон нутагт тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	-	-	Депутатуудад хүндэтгэл үзүүлсэн	Бүгд найрамдах улсыг тунхаглаж, анхдугаар үндсэн хууль баталсны 100 жилийн ойг орон нутагт тэмдэглэн өнгөрүүлэх, ойн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний хөтөлбөрийг аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн “Бүгд найрамдах улсыг тунхаглаж, анхдугаар үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/882 дугаар захирамжийн хүрээнд төрийн байгууллагууд холбогдох арга хэмжээг зохион байгуулан ажиллаж, тус аймгаас Үндсэн хууль батлалцсан депутатуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажиллаж, үйл ажиллагааны талаарх тайланг Улсын Их хурлын Тамгын газарт тайлагнан ажилласан.	2024.11.2 2024.12.04	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь

	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1.1. Цахим шилжилтэд суралцана.	Суралцсан эсэх	2023 онд УА- ын дунд хугацааны сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан.	60%	Сумдаас эрх зүйн ажлын мэдээ, тайланг цахимаар авч бүртгэл хөтлөн тогтмолжуулаад байгаа бөгөөд мөн эрх зүйн сургалт, сурталчилгааг цахимаар түлхүү зохион байгуулахад анхаарч нийт сумдад эрх зүйн хөтчийн цахим мэдээллийн буланг ажиллуулахаар зорилт тавин ажиллаж байна. Мөн аймгийн Сонгуулийн хорооны сургалт мэдээлэл хариуцсан ажилтнаар ажиллаж сонгуулийн ерөнхий хорооны цахим системд тогтмол ажилласан.	2024.01.10 2024.10.15	90.0
2.	Арга хэмжээ 1.2. Мэдлэг чадвараа нэмэгдүүлэх сургалтад хамрагдана.	Суралцсан эсэх	-	50%	Хууль зүй, дотоод хэргийн яамны сургалтын https://surgalt.mojha.gov.mn системд 04 дүгээр сарын 22- ны өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд Захиргааны ерөнхий хууль болон Захиргааны хэм хэмжээний актын цахим сургалтад хамрагдсан. Мөн Удирдлагын академиас тус аймагт зохион байгуулсан Хөгжлийн бодлогын хэрэгжилт-сэтгэлгээний өөрчлөлт сэдэвт сургалтад болон Улаанбаатар хотод Удирдлагын академи дээр	2024.04.22 2024.11.13	100.0

					Залуу мэргэжилтнүүдийн ментор бэлтгэх сургалтад 11 дүгээр сарын 12,13 өдрүүдэд тус тус хамрагдаж мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

З.НАЦАГНЯМ

2024 оны 12 дугаар сарын 05